

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Мандал Даатгал ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 04 сарын 23-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1 ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ